

НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА,
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙН ҮЕД ХАМТРАН АЖИЛЛАХ
ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

2017 оны 01 сар 06 өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас Иргэний нисэхийн ерөнхий газар /цаашид "ИНЕГ" гэх/, нөгөө талаас Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /цаашид "НТОЗШША" гэх/ хамтран ажиллах талаар дор дурьдсан асуудлаар харилцан тохиролцож, энэхүү санамж бичгийг үйлдэв.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Санамж бичгийн зорилго нь Иргэний нисэхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4, 42.5, 42.6. дахь хэсэг, Иргэний нисэхийн багц дүрэм болон Олон Улсын Иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын баримт бичгийн хүрээнд нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангуулах болон агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагааны үед хамтран ажиллах, харилцан дэмжлэг үзүүлэхэд оршино.

1.2. Хамтын ажиллагаа нь хуулиар хориглоогүй асуудалд ил тод нээлттэй байх, хамтын ажиллагааны үр дүнг нэгтгэн хэлэлцэх, харилцан хүндэтгэлтэй хандах зарчимд тулгуурлаж, үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль, тогтоомж, олон улсын гэрээний заалтыг удирдлага болгоно.

Хоёр. Хамтын ажиллагааны зарчим

2.1. Хамтын ажиллагаа нь дараах зарчимд тулгуурлана. Үүнд:

2.1.1. НТОЗШША-ны үйл ажиллагааны хараат бус байдлыг хүндэтгэх бөгөөд осол, зөрчлийн шалтгааныг тогтоох, урьдчилан сэргийлэх зорилгод бүх талаар хамтран ажиллах,

2.1.2. мэдээ мэдээлэл, өгөгдлийн үр дүнтэй, үр өгөөжтэй солилцоог бий болгох,

2.1.3. нээлттэй, ил тод чөлөөтэй харилцах,


2.1.4. аливаа маргаан, зөрчилдөөн, ойлгомжгүй асуудлыг хоёр байгууллагын удирдлагын түвшинд, хурдан шуурхай, харилцан ойлголцож, шийдвэрлэх.

Гурав. Талуудын хүлээх үүрэг

3.1. НТОЗШША нь Иргэний нисэхийн тухай хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд агаарын хөлгийн осол ноцтой зөрчлийг Чикагогийн конвенцийн Хавсралт 13-ыг баримтлан ангилан бүртгэж, осол, ноцтой зөрчил болон зарим зөрчлийг шинжлэн шалгаж тайлан дүгнэлтийг Чикагогийн Конвенцийн 26 дугаар зүйл, Чикагогийн Конвенцийн Хавсралт 13, Док 9756, Док 9962 дагуу гаргана.

3.2. НТОЗШША нь агаарын хөлгийн осол ноцтой зөрчлийн шалтгаан нөхцлийг тогтоох ажиллагаанд хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулж тухайн осол, зөрчлийн учир шалтгааныг шинжлэн тогтоож, дахин давтагдан гарахаас урьдчилан сэргийлэх зорилго бүхий аюулгүй ажиллагааны холбогдох зөвлөмжөөр хангана.

3.3. ИНЕГ нь Чикагогийн Конвенцийн Хавсралт 13-ын дагуу зөвлөмжийг хүлээн авсанаас хойш 90 хоногийн дотор осол, зөрчлийг шинжлэн шалгасан тайлан, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлж буй арга хэмжээгээ НТОЗШША-нд эргэн мэдэгдэх ба Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, 8.7-д заасны дагуу агаарын хөлгийн осол ноцтой зөрчлийг шинжлэн шалгасан дүгнэлтийг үндэслэн цаашид осол, зөрчил



давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хянан зохицуулах үйл ажиллагааны тогтолцоог бүрдүүлнэ.

3.4. НТОЗШША нь шинжлэн шалгах ажиллагааны тайлангийн төслийг Чикагогийн Конвенцийн Хавсралт 13-т заасны дагуу ИНЕГ-т хүргүүлэн санал авах ба ИНЕГ нь шинжлэн шалгах үйл ажиллагаа бүрэн дуусгавар болтол нийтэд аливаа мэдээллийг задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

Дөрөв. Нислэг техникийн осол, зөрчлийн талаар мэдээлэх

4.1. Аливаа агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн мэдээллийг анх хүлээн авсан тал нь нэн даруй нөгөө талдаа мэдээлнэ.

Шуурхай мэдээллийн утас.

- НТОЗШША: 95953399
- ИНЕГ-ын НААХЗА: 98985525

Тав. Хамтын ажиллагааны хяналт

5.1. НТОЗШША болон ИНЕГ нь 6 сар тутам хуваарьт уулзалтыг зохион байгуулж, дараах асуудлуудын хүрээнд санал солилцоно. Үүнд:

- 5.1.1. үйл ажиллагааны болон хамтын ажиллагааны төлөвлөгөө,
- 5.1.2. аюулгүй ажиллагааны зөвлөмж болон түүний хэрэгжилт,
- 5.1.3. нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын явцад илэрсэн аюулгүй ажиллагаатай холбоотой асуудлууд,
- 5.1.4. шинжилгээ, судалгааны аливаа хөтөлбөр, түүний хэрэгжилт, үр дүн,
- 5.1.5. аюулгүй ажиллагаатай холбоотой үйлдвэрлэлийн хандлагууд,
- 5.1.6. хүний хүчин зүйлийн асуудлууд,
- 5.1.7. үйл ажиллагааны бодлого болон журмууд,
- 5.1.8. ажилтнуудын сургалт, дадлага туршлагыг дээшлүүлсэн байдал.

Зургаа. Судалгаа, шинжилгээний талаар мэдээлэл солилцох

6.1. НТОЗШША болон ИНЕГ нь агаарын хөлгийн осол ноцтой зөрчил, нисэхийн аюулгүй ажиллагаатай холбоотой судалгаа шинжилгээнд шаардлагатай аливаа мэдээллийг холбогдох хууль, дүрмийн хүрээнд мэдээлж, харилцан санал солилцоно.

Долоо. Олон нийтийн харилцаа, хамтын ажиллагаа

7.1. Олон улсын байгууллага, гадаад улс орнуудтай хийх уулзалт, хурал, хамтын ажиллагаан дээр хоёр тал Монгол Улсын ашиг сонирхолыг нэгдмэл, хамтач байдлаар илэрхийлнэ.

7.2. Шинжлэн шалгасан болон шалгаж байгаа аливаа осол, зөрчлийн талаар НТОЗШША олон нийтийн мэдээллийн сувгаар холбогдох мэдээллийг түгээнэ.

7.3. Талууд өөрсдийн үйл ажиллагаатай холбогдолтой мэдээллийг нийтэд өгч болох боловч нөгөө талын ашиг сонирхолд нөлөөлж болохуйц аливаа мэдээллийг хэвлэл мэдээлэлд өгөхөөс өмнө харилцан зөвшилцсөн байна.

Найм. Зардал хуваах болон нөхөн төлөх

8.1. Урьдчилан тохиролцсоноос бусад тохиолдолд талуудын харилцан үйл ажиллагаа нь үнэ төлбөргүй байна.

8.2. Аль нэг талаас гаргасан хүсэлтийн дагуу өртөг өндөртэй тусгай шинжлэн шалгах үйл ажиллагааг явуулахдаа хамтран төсөв гарган Зам, тээврийн хөгжлийн сайдад танилцуулж, батлуулж үр дүнг нь тайлагнана.



Ес. Зөвлөмж

9.1. Шинжилгээ судалгааны явцад Иргэний Нисэхийн багц дүрмийн, эсхүл бусад эрх зүйн баримт бичигт өөрчлөлт хийх, санал зөвлөмж гарах тохиолдолд Талууд урьдчилан харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.

Арав. Хамтын ажиллагааг дүгнэх

10.1. Энэхүү санамж бичгийн хэрэгжилтийг жилд нэг удаа, эсхүл аль нэг талын санаачлагаар хянан хэлэлцэнэ.

Арван нэг. Санамж бичгийг цуцлах болон нэмэлт, өөрчлөлт оруулах

11.1. Энэхүү санамж бичгийг цуцлах, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулах тухайгаа аль нэг тал нь нөгөө талдаа хуанлийн 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.


САНАМЖ БИЧГИЙГ БАТАЛГААЖУУЛСАН:

НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ,
ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ
АЛБАНЫ ДАРГА



Ж.ЦОЛМОН

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН